

ӨВӨГ ДЭЭДСИЙН НУТАГ ЭРЧИС МӨРНИЙ САВААР
-АЯН ЗАМЫН ТЭМДЭГЛЭЛ-

Орьяс Мөнгөнхүүгийн Ганболд*

Үрэмч хүрэх зам

Хурц нар ээсэн найман сарын эхээр Алтайн нурууг даван аяны замд гарсан билээ. БНХАУ-ын ШУӨЗО-ны Үрэмч хотноо зохион байгуулагдах олон улсын эрдэм шинжилгээний хуралд оролцох далимд Алтайн цаад биеэр аялж Алтайн урианхайн хошууны зарим нутгаар¹ явж ард түмний аж амьдрал, түүх, соёлтой танилцах боломж гарсан тул мордсон хэрэг. Пургон маркийн автобусанд хөл хөдөлгөх зайгүй, урагш хойш харан суусан залуус, хөгшдөөс бүрдсэн баг Ховдоос оройн нар шингэх цагаар хөдөлж, Хөшөөтийн гэж нэрлэх тосон замаар тойрч давхисаар наран мандах цагаар Булган сумын төвд хүрчихсэн билээ. Хэсэгхэн саатаж цай ууцгаан, банк орж юан солиод дахин ухасхийж Ярантын боомтод ирлээ. Найман жилийн өмнө ирснээс хойш эх орны баруун хилийн энэ бяцхан боомт үнэхээр гайхам өөрчлөгджээ. Хил гаалийн том саруулхан барилга барьжээ. Хяналт шалгалт хурдасч, үйлчилгээ сайжирсан нь илт. Ажилтнуудын хувцас жигдрэлт, үйлчилгээний соёл нь дээшилсэн байна. Шороон дундуур бараагаа чирэн хэн нэгнийг царайчлан хилээ нэвтрэх гэсэн хүмүүсийн зовонгуй царай энд харагдахаа болиод удсан ажээ. Хязгаарын боомт гэхэд олон улсын тийм хэмжээний байгууламжуудаас дутахгүй болсон байна. Эх орон хөгжиж байна эндээс тэр хөгжлийн царай үнэртэж байна гэж бодохоос бахдалтай. Монгол, Хятад хоёр орны хилийн боомтуудын хоорондох км орчим газрыг тосон замаар холбочихсон нь цүнхээ чирээд хөнгөхөн хүрчихдэг боломж олгожээ. Бид бүгд Хятадын хил нэвтэрч гарлаа. Тайкейшкан боомт руу манайхныг зөөдөг тусгай зөвшөөрөлтэй 5-6 хүний суудалтай жижиг тэрэгнүүд хүлээж байна. Түүгээр явах ёстой гэнэ. Өөр унаа ч харагдахгүй юм. Тэд журам дүрмээ ягштал биелүүлдэг болохоор зөвшөөрөл аваагүй жолооч нар хил рүү ирдэггүй аж. Ганц нэг тийм унаа таараад суувал нилээд асуудалд орооцолдоно гэнэ.

*М.Ганболд-Ховд Их Сургуулийн Түүхийн тэнхимийн профессор Ph.D.

Тайкешекан балгас төдийлөн өөрчлөгдсөнгүй. Наймаачдын агуулах лангуу гудамжны зохион байгуулалтанд орж, ганц нэг шинэ томоохон буудлын барилга нэмэгдснийг эс тооцвол. Хятад наймаачид бүгдээрээ л хазгай муруй монгол хэлээр ярьж байна. ...Чи сайн найзаа үнийг аваа. Энэ хамгийн сайн бараа гэх мэтээр. Бүр нэгэн хятад эр .. ямар ядаргаатай новш вэ гэж хэлж байх юм. 20 гаран жил бидэнтэй худалдаа хийсэн болохоор аргагүй биз ээ. Харин манай наймаачид хятад хэл сураагүй байх юм. Монголчууд нь тэндэхийн монголчуудаар, хасагууд нь хасагуудаараа “хэл ам хийгээд” явж байтал нэг мэдэхэд тэдний ч хэрэггүй болоод хятадууд өөрсдөө монголоор ярьж эхэлсэн байна. Монголчуудын хэнэггүй биеэ эс дайчлах зан, хятадуудын амьдралын төлөө үнэн хүчээрээ мэрийн зүтгэсэн он жилүүдийн наад захын үр дүн энэ бололтой. Гудамжаар гарлаа. Үрэмч явах унаа эрж байгаа юм. Ховдынхон дүүрчээ. Хоолны газруудаар орлоо. Монгол, хасаг хоол гэсэн хаяг их үзэгдэнэ. Булган голын дагуу нутаглах уугуул монгол, хасагууд энд суурьшин хоолны газар ажиллуулдаг байна. Өндөг, ногоотой хоол давамгай ажээ. Оройхон эхнэр бид хоёр Үрэмч хотод суралцахаар яваа хэдэн охидын хамт Чингэл сум руу хүргэж өгөх хасаг жолоочтой жижиг автобусанд суулаа. 60 км газрыг цаг орчим давхиад Чингэлд ирлээ. Алтайн цаадах Чингэл голын хөвөөнд. Монгол Алтайн нуруу дамнан сууж байсан Алтайн урианхайн 7 хошууны нутаг нь Монгол улсын талдаа Ховд, Сагсай, Сэнхэр, Дэлүүн, Хятад улсын талдаа Өрөнгө, Чингэл. Ээв, Эрчис гэсэн томоохон голуудын сав газрыг багтааж байсан юм. Тэгэхээр Алтайн урианхайн Баруун гарын Дархан бэйсийн хошууныхаа нутагт л явна гэсэн үг. Чингэл гол чимээгүйхэн урсана, эрэг хавийн нутгийг бүхэлд нь тариан талбай болгож, засмал зам тавьжээ.

Ойр хавийн дов толгод дунд ганц монгол гэр үзэв. Тэмээ хариулж байгаа бололтой. Алсад зүүн гар талд Алтайн нуруу хөхрөн суналзана. Түүний цаана Булган, Сэнхэр голын урианхай, торгууд нар бий. Хуваагдан салсан түүхийг яривал их цаг цаас орох юм. 1930 онд аавын минь нагац Цэрэнпил гэдэг эр гагц биеэр Алтай давсан Чүлтэм да лам² тэргүүтнийг дагалдан энд ирсэн гэж байгаа. Үр сад нь энд явдаг л байх даа. Сураг чимээ гаргаж чадахгүй л явна. Бид эндээс унаагаа солин шинэвтэр хүн тээврийн тэргэнд суулаа. Ачаагаа ачихаар гарахад Монголчууд тосож байна, тэргэндээ ороод суухад дуучин Самандын Жавхлан дуулна. Тэд Чингэлийн Алтайн урианхайчууд ажээ. Төдөлгүй л хоёр газрын алтайн урианхай нар танилцав. Машины эзэн Баттөмөр нэртэй намхан хүдэр залуу

Алтайн урианхайн Оорцог³ сумнаа Хорхон элкэн⁴ гэнэ. Цэргийн алба хааж ирээд одоо Чингэлийн засгийн ордонд алба хашдаг ажээ. Хятадад төрийн албанд орохын тулд тавигдах нэг шалгуур нь цэргийн алба хаасан байх шаардлагатай гэнэ. Хэдэн зуун саяар тоологдох идэр эрчүүдтэй Хятад оронд хир баргийн залуу цэргийн албанд тэнцдэггүй бололтой юм. Тэнцээд алба хаагаад ирсэнд нь төрийн албанд орох боломж бараг зуун хувьтай байдаг гэх. Тийм шалгуурыг бүрэн давсан энэ хөвүүн нутагтаа хасаг⁵ бөхийн барилдааны олон удаагийн аварга болжээ. Чингэлийн цөөн алтайн урианхайчууд угсаатны олон өвөө мартаж байгаагийн нэг нь үндэсний бөх барилдахаа болиод уджээ. Хааяа зохиогдох нийтийн баяр, той хуримын үед залуус нь хасаг бөх барилддаг байна. Хүн амын дийлэнх болсон хасагуудын бөхөд нэг урианхай залуу олон удаа түрүүлсэнд тэд сүүлдээ ихэд дургүйцэн мань залуу ч барилдахаа орхисон гэнэ. Ажлынхаа зав чөлөөгөөр машин худалдан авч дүүгээ дагуулан Үрэмч-Чингэлийн хооронд зорчигч тээвэрлэдэг бөгөөд энэ удаа бидэнтэй таарчээ. Машинадаа замын туршид интернэтээс татаж авсан манай дуучдын дуулсан ардын болон зохиолын дуу сонсож, дагаж дуулахыг оролдож явах нь “саллаа гээд салсангүй мааным, салангид замын эхээр саллаа” гэсэн урианхайн ардын дууг сэтгэлд бодогдуулна. Чингэлээс Үрэмч орохоор тэдний дэргэд залуу бүсгүй яваа нь ихэд хүндтэй нэгэн аж. Учир нь тэр бүсгүй ноён ламын бэр гэлцэнэ. Ноён лам гэдэг нь дээр өгүүлсэн Дархан бэйсийн хошууны ноён Самбуугийн Чүлтэм да лам. Чүлтэм да ламд Батбаяр, Батнасан гэсэн хоёр эрэгтэй дүү байж, Батнасангийн ач хүүтэй бидэнтэй зэрэгцэн яваа бүсгүй гэрлэсэн тул нутгийнхандаа “Ноён ламын бэр” хэмээн хүндлэгдэх болжээ.

Зам зууртаа Чингэл сумын нутагт Цахиуртай гэх газар нүүрсний уурхай нээгдэж “өрүүн асгангоо нүүрс маажиж” байгааг үзэв. Зогсоо зайгүй нүүрс тээвэрлэх том тэрэгнүүдийг харахад хятадуудад манай Хөшөөтийн нүүрс ямар хэрэгтэй юм бол гэсэн бодол төрнө. Бидний ярианд сэтгэл эмзэглүүлсэн олон зүйл байсны дотор Чингэлийн залууст хасагууд нь бид нэг гаралтай, ахан дүүс, ах сумын албатууд байсан хэмээн итгүүлсэн явдал байлаа. Үнэн тийм байв уу, одоо танай нутагт ах сумын хасагууд байна уу гэх мэтээр тэд асууж байсан. Сүүлийн жилүүдэд залуус харь элгийнхэнтэй мэр сэр гэр бүл болох болжээ. Тэдгээр алтайн урианхай залуус надад *...танай ерөнхийлөгч биднуусийг Монгол нутагтай ирнэ уу гэсэн. Яваад одвол тануус муу хужаа гээд ад үзэх байх даа. Бидэнд өдөр болгон хасагууд Казахстан улс хучирхэгжин хөгжиж байна хэмээн*

бардамнадаг гэж өгүүлэн Монгол улс минь хэзээ сайхан хөгжих бол гэж асуухдаа хоолой нь зангирч байсныг хэлэх хэрэгтэй. Төрсөн нутагтай ч боловч харь гүрний засаглал дор амьдарч байгаа тэдгээр залуусын хэлсэн үг ихийг бодогдуулсан билээ. Бид ийнхүү элдвийг хүүрнэн явсаар үүр цайхын хирд Үрэмч хотноо хүрч ирэв. Ховдоос гараад 48 цагийг өнгөрүүлжээ.

БНХАУ-ын ШУӨЗО-ны нийслэл Үрэмч хотноо

Шинжианы ойрадууд Үрэмч гэдэг нь Өрөмт гэсэн үгнээс гаралтай. Өрөмт голын хөвөөн дээр үргэлж л сүү, өрөм бялхаж байдаг нэгэн монгол малчин айл нутаглаж байсан тул тэр газрыг Өрөмт гэж нэрлэсэн. Тэр монгол нэр явсаар Үрэмч болсон гэж ярилцдаг юм. Шинжиан⁶ Уйгурын Өөртөө Засах Орны Засгийн газрын дэмжлэгтэйгээр Шинжиангийн их сургууль, Алтай аймгийн Засгийн ордон хамтран *"Торгоны замын дагуух улс орнуудын нийгэм эдийн засгийн хөгжил, угсаатны өв соёл"* сэдвээр олон улсын эрдэм шинжилгээний хурлыг 8 сарын 3-12-ны өдрүүдэд зохион байгуулав. Хятадын их сургуулиуд, Орос, Америк, Япон, Сингапур, Солонгос, Казахстан, Узбекистан, Киргизстан зэрэг олон орны эрдэмтэд оролцсон энэ хуралд Монголоос МУИС-ийн профессор Ж.Бат-Ирээдүй бид хоёрыг урьсан байна. Хурлыг Үрэмчийн "Кунлун" хэмээх таван одтой зочид буудалд эхлүүлэн, Алтай аймгийн нутгаар аялал судалгаа зохион байгуулан Алтай хотноо дуусгасан юм. Кунлун буудлыг аль 1950-д оны үед Оросууд барьж өгчээ. Хуучин нүсэр том барилга. 1990-д оны үед буудлыг нураах эсэх талаар ард иргэдээсээ санал асуусанд "Түүхийн дурсгал" хэмээн эс зөвшөөрсөнд шинэчлэн засварлаж 5 одтой зочид буудал болгожээ. Харин бид Сталины хөшөө, Цагаан хаалга, Лениний хөшөө гээд л түүхийн дурсгалыг нэг нэгээр нь нураасаар байх юм. Хуралд зориулан хөтөлбөр, илтгэлийн хураангуй, эрдэмтдийн танилцуулга, холбоо барих хаяг, буудалд байршсан өрөөний дугаар, өрөөнүүдийн хооронд холбогдох утас, илтгэлээ хэлэлцүүлэх цаг зэргийн нарийн мэдээлэл бүхий материаллыг хэвлүүлэн бэлтгэжээ. Харин хуралд нэг илтгэгч 10 минут авна. Илтгэлийн завсарлагаагаар асуулт хариултын цаг үгүй. Хурлын чөлөө цагаар эрдэмтэд уулзаж санал бодлоо солилцох бүрэн боломжтой. Буудлын нэг өрөөнд нэг хүн байрлуулжээ.

Үрэмчид байсан хугацаанд бидэнд ажиглагдсан зарим зүйлсийн талаар өгүүлье. Шинжаан уйгурын орон дотроо хэд хэдэн аймгуудад хуваагддаг. Аймаг бүхэн Үрэмч хотноо төлөөлөгчийн

газар ажиллуулдаг байна. Тийм газар нь хурлын танхим, уулзалтын өрөө бүхий зочид буудал байх юм. Иймээс Баянгол аймгаас ирсэн хүмүүс шаардлагатай бол өөрийн аймгийн төлөөлөгчийн газарт буудаллана. Хурал зөвлөлгөөнөө хийнэ. Үрэмчид амьдарч байгаа нутгийн иргэдийнхээ дунд уулзалт ярилцлага, үдэшлэг концерт зохион байгуулна. Хувийн өмчийн өргөн уламжлал, өндөр соёлтой Хятад оронд аймгууд ийм газруудтай байх нь нэр төрийн хэрэг бололтой юм. 3 сая гаруй хүн амтай Үрэмч хотын бүтээн байгуулалт содон. Мэдээжийн өндөр барилгууд, өргөн гудамж, зам талбай, хамгийн сайхан нь хотын ногоон байгууламжууд. Мод бутыг зүгээр нэг суулгаад орхино гэсэн ойлголт хятад хүний оюун санаанд байхгүй. Түүгээр байшин барилга, амьтан араатан, мал сүрэг, жигүүртэн шувуу, өт хорхой ер нь юм болгоныг “ургуулан” босгон услаж тордож байх нь өдөр тутмын маш гол ажил юм. Газар тариалангийн гайхамшигт уламжлалын нэг энэ ажээ. Үрэмчээс гадна бидний очсон олон хот тосгодод хятад, уйгур, хасаг, монгол, чантуу хуйхуй хэн амьдарч байгаагаас үл хамааран бүхэлдээ ургамал, мод бутаар ургуулан урласан өнгө өнгийн түмэн янзын бүтээн байгуулалт таарах юм. Үрэмч хотын төв замын уулзварт Хятадын төрийн далбаа, гал улаан дээр таван хошуу, Пуян хотноо домгийн луу, хоёр бөхтөй тэмээ гэхчлэн үзэгдэнэ. Монголчууд хурдан мориныхоо дэл сүүлийг засаж боох мэт өдөр болгон л тэдгээр ургамлан амьтдыг засаж хайчлан, услаж ургуулан өнгө үзэмжийг нь гял цал болгож харагдана.

Гудамж талбайд тарьж ургуулсан чимэглэлийн цэцэг навчны өнгө үзэмж гайхалтай, долоон өнгөөр л солонгорон харагдаж ёстой л “нүд баясгаж, сэтгэл сэргээх” ажээ. Хүмүүс хот байгуулан, түүнийгээ өөртөө зориулан тохижуулж, дэг журам тогтоон тав тухтай аж төрж болохыг Үрэмчээс харж болно. Саяхан нүүдэлчдийн нутаг байсан Үрэмч эдүгээ суурин соёл хот байгуулалтын гайхам жишээ болон хувирчээ. Би Орос, Австри, Унгар, Польш, Герман, Чех, Япон, Солонгос зэргийн олон орноор явж байсан. Хот байгуулалтын соёлын хувьд Үрэмч тэднээс дутахааргүй болжээ. Суурьшиж байгаа Монголчуудын хувьд хотын соёлд суралцахаас өөр замгүй. Үүнийг бид ялангуяа залуу үеийнхэнд ухааруулах цаг болсон байна. Тэгэхгүй бол монголчууд зам бариад эвддэг, хот босгоод нураадаг, дэлгүүр гуанз, сургуулийнхаа дэргэдүүр зүгээр өнгөрч чадахгүй заавал “морь хардаг” зангаа гээхгүй хэдэн арван жилийг үзэх буй заа.

Үрэмчийн өөр нэгэн гайхалтай зан үйл бол нийтийн эзэмшлийн

талбайг хүн ардын төлөө ашиглах дадал юм. Хотын хороолол бүрд хэмжээгээр тийм ч том биш Ховд хотын төвд байх Ард Аюушийн талбайг дөрөв хуваасны нэгтэй тэнцэх хэмжээний талбайнууд бий. Орос хот, тосгодод байдаг "танец площадка" шиг зориулалтын биш боловч тэр талбайдаа орой бүр хятад, уйгур хүмүүс нас хүйс зэрэг дэвээ үл харгалзан бөөнөөрөө цугларан хөгжим эгшиглүүдэн үндэсний онцлог, ахуй ухамсраа илэрхийлсэн нийтийн бүжгийг "хажуу газрыг халцартал, довцог газрыг тэгширтэл" хол ойрын амьтныг цугларч алмайртал хийцгээх юм. Өдрийн их ачааллын дараа алжаалаа тайлах сайн арга. Хятад хүмүүс бүгдээр гайхалтай зохион байгуулалтанд орж жигдрэн жигдхэн нэгэн хэмээр бүжгийн орчин үеийн хэмнэл бүхий хөдөлгөөнийг тун ч алдаа гаргаж зөрөлгүй хийх нь багц шүдэнзийг жижигхэн хайрцганд багтаан хармаалахын адил сэтгэгдэл төрүүлнэ. Хайрцаглана гэж ярьдаг даа. Тийм юм. Харин уйгур хүмүүс бол задгай талбайдаа таран бутарч хос хосоороо морьтон дайчид давхин өнгөрөх мэт, хуй салхи дэгдэн ирэх мэт огцом хурц үзүүртэй гэрлэн сүлбээ мэт эрэлхэг, түрэмгий аястай хөдөлгөөнт бүжгийг гал цахилгаан бадрах адил сүртэй омог бардам хийцгээх юм. Бүжиглэгч уйгуруудын цус нь буцалж байгаа байхдаа гэж бодогдохоор. Соёл иргэншил, угсаа гарал, үзэл бодол, амьдралын төлөө их тэмцэл, туулсан замнал нь тэдгээр ард түмнүүдийн оройн цагийн гудамжны бүжигнээс нь их тодорхой харагдана. Хүмүүс ажиллаж, амарч амьдардгийг эндээс үзэж болно. Шинжааны нүүдэлчин ойрадууд, хасагууд ч өөрийн бүжигтэй. Тэд гудамжинд нийтийн эзэмшлийн талбайд хуран цугларч бүжихгүй ч ойрадууд "савардан"-гаа, хасагууд "хара жороо"-гоо нүүдлийнхээ отог, урлагийн тайзнаа, хоолон гэрт аль алинд нь бүжиглэцгээнэ.

Ийм хүмүүс хэзээдээ өөр хоорондоо тэмцэж буу шийдэмдээ хүрдэг бол гэж бодмоор. Хэдийгээр хятад, уйгур, хасаг, монголоороо нэгдэн нийлээд дуулж бүжиглээд гудамжаар зугаалаад байхгүй ч бие биеийнхээ хийж байгаад саад болохгүй, дорд үзэж хялайхгүй, эвтэй найртай үзэгдэнэ. Өөр өөрийн зам мөрөө хөөсөн хүмүүс л харагдацгаах юм.

Шинжаан орон уйгурын өөртөө засах нутаг болохоор уйгурын соёл ахуй амьдралын дүр зураг алхам тутамд таарна. Гудамж талбай, гуанз ресторанууд хятад, уйгур, хасаг, монголоороо ялгарах өөрийн нэрийн хуудас болсон бүтээгдэхүүнтэй. Уйгуруудад бол нэг дүгээрт нан, хоёрдугаарт полов бий. Янз бүрийн хэмжээгээр төрөл бүрийн орц найрлагатай нан буюу биднийхээр гамбирийг хоолон гэр ажиллуулж байгаа бүх гудамж талбайд газар дээр нь хийгээд

савлаад өгнө. Төмөр хөлтөй нан хайрах бяцхан тогоо, элдэж тэнийлгэх модон ширээ байрлуулж цагаан хормогч өмсөж цагаан малгай цохдсон уйгур эрчүүд, гавшгай шаламгай. Дэргэд нь эхнэр хүүхдүүд нь туслалцан гүйлдэнэ. Гудамжин дахь гэр бүлийн бизнес орлоготой. Тэдний хийсэн амтлаг зөөлөн нанг зөрж өнгөрсөн түмэн хэлийн хүмүүс авцгаана. Хоёр гурван удаа авсан нөхцөлд холоос танимхайран чанга дуугаар хашгиран угтах ажээ. Ахиад хүрээд ирэв үү аваарай л гэж байгаа бололтой. Зоогийн, тэр дундаа жижиг газруудад бол полов элбэг хийх ажээ. Ховдын театрын удирдаач Ардын жүжигчин М.Яасай ахын хийдэг байсантай адил тослог полов. Гэхдээ луувангийн орц нь бага юм шиг санагдсан. Үрэмч хотын төвд байрлах уйгурын зах бол жинхэнэ энэ ард түмний соёлын төв голомт болсон байдаг. Найман жилийн өмнөхөөс жигтэйхэн их томорч өөрчлөгджээ. Гаднах талбайн зай багасаж зорин очих хүмүүсээ багтаахаа больжээ. Тэр захад “нохойн битүү туурай ногоон хурганы арьснаас” бусад нь бий. Хятадын удирдагч Мао Зедуны зэс, гууль, мөнгө, алт, хаш чулуу, шавраар хийсэн том жижиг хөрөг баримал гэхэд нэгэн том дэлгүүрийн зай эзэлмээр аятай. Хятадын их гүрний бодлогыг эсэргүүцсэн уйгурын бослого тэмцэл энэ хавийн гудамж талбайд болсон гэлцэнэ. Тийм зүйл болоод өнгөрсний ул мөр үнэхээр мэдэгдэхгүй. Амьдрахын төлөө мэрийн гүйлдсэн хүмүүс үзэгдэнэ. Уйгур газрын мянган нэрийн жимс, гоёл чимэглэл, хувцас өмсгөл, бэлэг дурсгал, аяга тавга, хутга шөвөг, тоглоом наадгай гээд л эд бараа дүүрэн. Дунд нь бүр “Монгол Эрдэнэтийн хивс” гээд монгол бичгээр бичсэн хаягийн дор алаг хивснүүд өлгөжээ. Монгол залуу уйгуруудтай хамтран хийж байгаа худалдаа гэнэ. Уйгур хүн хаана байна тэнд дуу шуугиан, инээд наргиан, бүр хашгичаан сонсогдоно. Хоолны газар ороод нэг ширээнд суусан хэдхэн хүн хүртэл бөөн дуу шуугиан татаад явчихна. Хамт яваа нэгнээс асуулаа. Тэр уйгурууд их л хөгжилтэй юм ярьцгааж байгаа байх даа гэж. Тэгсэн чинь надад ингэж хэлж байна. *..Хөгжилтэй зүйл ярих гэж инээлдэж байгаа юм. Нэг нь би та нарт инээдтэй зүйл ярьж өгье* гэхэд л нөгөөдүүл нь инээлддэг гэнэ. Тийм ч юм болов уу. Ямартай л хөөр баясал давамгайлсан хүмүүс байх ажээ. Үнэхээр хөгжилдөхөөр яриа үүсвэл яах бол гэж бодмоор.



Үрэмчийн гудамжин дахь Уйгур бүжиг. 2012.08.0

Өндөр Алтайн өргөмжөөр....

Өндөр Алтайн өргөмжөөр өрүүнээ наран мандана

Үргэлжид сэрүүн байдаг ямархан сайхан Алтай вэ ...хэмээн

Ойрад ардын дуунд өгүүлдэг. Аагим халуун амьсгалтай Үрэмч хотоос яг л энэ дууг санагдуулан алсад дүнхийх Алтай уулыг зорин бид өглөөний нарнаар хөдөллөө. Хуралд оролцогчид Алтай аймгийн⁷ нутгаар аялал судалгаа хийх гэж байгаа юм. Хотоос гарах хурдны замд нэг машин “өнхөрч” таараад хэсэг саатсаныг эс тооцвол бид өдөржин давхисаар оройн нар жаргахын өмнө Эрчис мөрний эрэгт байрлах Пуян суманд ирлээ. Монголчууд бол Буян гэж байсан. Алтай уулын баруун сугад байрлах жижигхэн хот. Жуулчид их ирдэг болохоор өнгө төрх шинэчлэгдэн өөрчлөгджээ. Алтай аймгийн Хөх тохой сумын нутаг. Хасагууд голлон сууна. Зочид буудал, хоолны газар дэлгүүр лангуу орчин цагийнх. Гэхдээ хотын захаар хятад тариачин иргэдийн газар наалдсан шавар тагзууд, бохир заваан хашаа хороо үргэлжилнэ. Агаар нь хачин цэвэрхэн тэнгэр цэв цэнхэр ажээ. Зам барилгын их ажил өрнөж байгаа нь мэдрэгдэнэ. Өдөржин давхисан газар газрын олон хэлийн хүмүүс ширээ дүүрэн хоол руу ухасхийлээ. Хүнд ажлын дараа хооллох нь хятад газрын хүмүүсийн нэгэн жаргал байдгийг эндээс харав. Түмэн янзын тансаг хоолноос амтархан бүр инээмсэглэн “цохиж” байгаа нь цаанаа л нэг “шунамгай”. Бид яаж дутахав дээ. Алтай аймгийн нутагт ирсэн болохоор аагтай шаргал цайтай юм. Манж нар Зүүн гарын хаант улсыг байлдан эзлэж Амарсанаа тэргүүтний бослогыг дарж их хядлага явуулсны дараа “...Эрчис мөрний эхээр хүн ам цөөрч төдөлгүй хар хасаг цөмрөн орж ирсэн” тухай түүхэнд өгүүлдэг. Тэр цагаас хойш 240 шахам жил өнгөрчээ. Нутгийн уугуул монголчууд аль хэдийнээ цөөнх болон суужээ. Харин газрын нэр голдуу

монголоороо байх юм. Буян, Хөх тохой, Буурал тохой, Тэмээт, Хандгайт, Эрчис, Өрөнгө, Чингэл, Эвийн гол гэх мэтээр. Манай нутгийн өвгөд урианхайн хошууд Хөх тохой, Цагаан тохой, Буурал тохой, Булжим тохой, Шар тохой, Гүн тохой, Уужим тохой гэсэн долоон тохой нутагтай байсан юм гэнэ лээ гэдэгсэн. Нэг нь энэ Хөх тохой. Эрчис мөрний саваар униартсан их нутаг. Буянд бид Зүүн гарын хотгороос олдсон үнэт чулууны ховор сайхан үзмэр үзэв. Сүүлийн жилүүдэд Хятадад үнэт чулуун эдлэлийн урлал хөгжиж үнэ ханш нь өсөж жуулчдад зориулсан ашигтай бизнес болсон байна. Хачин чамин үнэт чулуунуудыг хэдэн зуугаар нь дэлгэн тавьсан үзмэрээс байгаль эх хамгийн агуу уран бүтээлч гэдгийг харав. Хүний гараар бүтэмгүй нандин урлалыг байгаль эх Зүүн гарын хотгорын хуурай сайр дунд бүтээж түүнийг хүмүүс олж дэлгээд бие биедээ үзүүлж сууна. Хүн төрөлхтөн өөрөө байгаль эхийн хүүхдүүд шүү дээ гэсэн бодол төрнө. Энэ үзмэрт байсан өөр нэгэн сонирхолтой үзмэр бол үлэг гүрвэлүүдийн араг яс. Зүүн гарын хотгороос олдсон энгийн ойлголтоор бол дунд зэргийн үлэг гүрвэлүүд. Ихэнхийнх нь араг яс нь нас гүйцсэн үхрийн хэмжээний юм. Зарим нэг нь түүнээс дөрөв тав дахин том. Бүр долоон араг яс угсран эвлүүлэн тавьсан байх ажээ. Манай эх орон тийм “батаруудын” музейтэй болбол тун ч хэрэгтэй. Үзмэрт Алтайн нуруу, Зүүн гарын хотгорын ан амьтан, жигүүртэн шувууд, түүхийн зарим дурсгал хүн чулуун хөшөөд, модон урлал сийлбэр зэргийг зэрэгцүүлэн тавьжээ. Үзмэрийн барилга жинхэнэ зориулалтын шинэ байв.

Буян суманд байх баазаар жуулчид олноор дамжин өнгөрдөг бололтой юм. Машин хөлөглөж эхнэр хүүхдээ дагуулсан цаанаа л нэг санаа амар эрхэмсэг эрчүүд нүдэнд олонтой харагдана. Буянд хоноглосон бид маргааш өглөө нь Эрчис мөрний эхэнд байгуулсан газар зүйн тогтоц, хувирлын түүхийг харуулсан үзмэр бүхий жуулчны бааз руу хөдөллөө. Энэ бол маш сайн дэд бүтцийг бий болгосон Эрчис мөрний эхэн хавийн газар нутгийг үзүүлэх зориулалттай газар юм. Манай улсын хилээс цааш тун холгүй байна⁸. Эрчис мөрнийг зарим газарт Эртэш гэнэ. Эрчис мөрөн Алтайн нуруунаас ах аван Хятад, Казахстан, Орос зэрэг орны нутгаар хөндлөн урсаж Гадаад их далайд цутгадаг. дэлхийд том мөрнүүдийн нэг. Уг нэр нь эрчилсэн их ус, хүчтэй урсгалтай гол гэсэн монгол үгнээс гаралтай нь ойлгомжтой. Мөрөн түрэг угсаатны нутгаар дайран өнгөрөхдөө Эртэш нэрийг авсан бизээ. Одоо тэнд нутаглан суугчид Эртэш гэдэг нэрээр нь нэрлэж байна лээ. Бид ч уг нэр нь Эрчис шүү дээ хэмээн чадах ядахаараа л “мэтгэлцэж” явав. Буянгаас 60

орчим км явж нэгэн давааг давж, өргөн хөндий өгсөн тосон замаар давхисаар мөнгийг нь малтаад авсан хуучин уурхайг аялагчдад зориулан үзмэр болгосныг үзээд 2 цагийн дараа зорьсон газраа ирлээ. Хавцал өгсүүлсэн замаар алгуурхан өгсөж явахдаа Алтай хар тарвага, бор туулай, улаан үнэг зэргийг үзэв. Ан амьтан элбэг дүү хүн машинаас нэг их үргэж цочдоггүй бололтой. Өглөө эртхэн ирсэн боловч аль хэдийнээ хүн дүүрчээ. Дотоодын жуулчин хятад голдуу хүмүүс. Хөл гишгэх зай алга. Гэхдээ үйлчилгээ нь хурдан юм. Менежерүүд бололтой хармааны дуу өсгөгчтэй залуучууд чанга чанга хашгиралдан хүмүүсийн дуудаж хуваарьт унаанд нь суулган авч одооцооно. Жуулчны баазын өргөн хашаанд ирээд том оврын автобусаа солин 10 орчим хүний багтаамжтай жижигхэн тэргээр голын хөвөөг өгсүүлэн тавьсан нарийхан замаар хэсэг өгслөө. Түүнээс цааш явган явах ажээ. Эрчис мөрнийг хөндлөн бетонон болон дүүжин гүүр зэрэгцүүлэн тавьжээ. Зам зуур үнэт чулууны худалдаачид саравч тавиураа бэлтгэн аль хэдийн аялагчдыг тоссон байна. Зарим нэг нь голын хөвөөнөөс бидний харж дадсан гөлгөр цагаан хар, шар өнгийн чулуунуудыг барин баясгалантай гүйлдэнэ. Тэр чулууг боловсруулан гар, хүзүүний зүүлт, бөгж, ээмэг, тоглоом зэрэг бэлэг дурсгалын зүйлсийг том жижиг янз бүрийн хэмжээ хэлбэр өнгө дүрсээр үйлдэж зарж борлуулж байна⁹. Тийм бэлгийг худалдан авч байгаа хүн гэдэг "далай" юм. Эрчис мөрний гүүрээр гарч уул өгсүүлэн тавьсан явган хүний замаар явж байгалийн бүтэц, үзэмжтэй танилцахад "аялал жуулчлал бол хүний сонирхлыг өөрт нь худалдах бизнес" гэсэн хаа ч билээ сонссон үг сэтгэлд бууна. Их хотын хүмүүс Алтай нуруунд ирж тийм үзэмж гоо байгалийг үзэхэд таашаал авалгүй яахав дээ. Жирийн шинжиан хүнд Алтайд төрөөгүй бол Алтайг ирж үзнэ гэдэг бараг л биелэшгүй мөрөөдөл дөө хэмээн Үрэмчид миний нэгэн танил өгүүлж байсан. Тэр үнэн байхаа бидний багт багтсан хятад, уйгур, хасаг хүмүүс үнэхээр их аз жаргалтай яваа нь мэдрэгдэнэ. Эрчис мөрний уснаас амслаа, эрэг дагаж их удаан явлаа, Алтайнхаа баруун энгэрээр нилээд өгслөө. Дэргэд нэг нөхөр ирээд их л удаан инээмсэглэж байгаад ярих юм. Яриан дунд нь монгол гэсэн үг гарах, зүс царай нь монголжуу. Тэгэхнээ дагуур монгол гэнэ. Гэхдээ "хайлсан" дагуур ажээ хөөрхий. Монголоос ирсэн хүмүүс гэдгийг дуулж л дээ. Тэгээд ирж байгаа юм. Даанч тэр маань "хайлчихсан" болохоор бид ойлголцсонгүй дээ. Дэлхий даяарт тархсан монголчуудын дотор ийм нь олон бизээ. Олзуурхууштай нь монгол гэх сэтгэл зүрхээ амархан гээдэггүй бололтой. Дараа нь тэр дагуур хүн бидэнтэй хэдэн удаа хамт нэг ширээнд суун хооллосон

билээ. Тэр цагт орчуулагчийн тусламжаар ярилцав. Монголд очиж үзэх сонирхолтой гэнэ. Монголд хайртай гэнэ. Монгол хүн амьдардаг хошуу сумаар явахдаа дуртай л гэнэ. Дандаа монголын тухай ярих тэр эр Бээжингийн их сургуульд эдийн засгийн онолын багш гэнэ лээ. Ийнхүү машинаар, автобусаар, явганаар явж замдаа худалдаа наймаа сонирхсоор Эрчис мөрний эхэнд нэгэн өдрийг таатайхан өнгөрүүлэв. Ойрмогхон хасагууд гэрээ барьж голын хөвөө даган бууж айраг цагаагаа эсгэн, сонирхож очигсдод унуулах морь тэмээ бэлтгэсэн үзэгдэнэ. Аялагчдын гарыг харж амттан зооглож сурсан бололтой сэгсгэр цагаан ямаа хаа сайгүй таарна. Төв суурин газрын улаан үхэр өглөөд бэлчээрт биш орон сууцны хог, хүнсний зах руу явдагтай агаар нэгэн. Гар тэнийлгэх төдийд гүйгээд ирэх эрх цагаан ишиг бас сонирхолтой байдаг бололтой.

Хөх тохойд бид амарч тухлаад алжаалаа тайлан цөөн хоног саатаад Алтай хотын зүг хөдөллөө. Алтай аймгийн төв Алтай хот. Алтайн нуруу тойрсон Орос улсад Уулын Алтай, Монгол улсад Говь-Алтай гэсэн хотууд бий. Их Алтайн нуруу дагасан гурван улсын гурван Алтай хотод би очжээ. Хэрэн голын хөвөөнд хүрч Алтайн шар сүмийн тууринд сүсэглэх чин хүсэл надад байсан юм. 1907 онд Манж Чин улсын Засгийн газар Ховдын хязгаарыг хоёр хувааж Алтайн нурууны баруун биеэр нутаглан суусан алтайн урианхай, торгуудын зарим хэсгийг хожим нутагшсан хасагуудын хамт Хэрэн голын хөвөөнд орших Алтайн шар сүмд захируулсан түүх бий. Тэрхүү Шар сүмийн туурин дээр байгуулагдсан хот бол Алтай юм. Хэрэн гол цагаан давалгаа хаялан урссаар. Харин Алтайн шар сүмийн туурь ч мэдэгдэхгүй болж, гагцхүү Алтай хотод буй хасагуудын угсаатны үзмэрт эрт нэгэн цагт энэ нутагт бурханы шашны томоохон сүм байсныг бүдэг бадаг илтгэх өнгө будаг нь халцарч муудсан хэдэн жижиг гуулин бурхан үзэгдэнэ. Шар сүмийн шавь нар Алтай аймгийн Хандгайт суманд нутаглан байна¹⁰. Өнөөгийн Хятад гүрний их хөгжлийн цар хүрээ хязгаарын Алтай хотод ч илтэд мэдрэгдэнэ. Зам талбай барилга байгууламж хэн ч хараажаар жинхэнэ шинжлэх ухааны төлөвлөлтөөр явагдаж байгаа нь илт. Жижигхэн, цэвэрхэн, цэмцгэр, хөл хөдөлгөөнтэй хот. Оросуудын хэлдэгээр “городок”. Алхам тутамд чулууны үйлдвэр чулуун баримлууд таарна. Гудамж талбайн зай хэмжээг гайхалтай ашиглан хасагийн ард түмний туулсан замнал, аж төрөх өвөрмөц ахуйг харуулсан гоёмсог, түүхэн сэдэвтэй хөшөө дурсгалууд босгожээ. Анх Алтайн нуруунд Эрчис мөрний эхэнд хасагийн дунд зуутын харьяат албатуудаа дагуулан нүүж ирсэн атаман Мамбетээс эхлээд унааны ганц морио эхнэртэй

унуулан хүүхдээ дүүрүүлж, хоёр тэмээнд гэрээ ачиж, цөөхөн хонь ямаагаа тууж, угжийн хургаа дагуулан хөндлөн модоор нуруугаа тэвхдэн алсыг зорин яаралгүй алхах хижээл хасаг эрийн, торхтой ус ачсан шар үхрийн гээд хэмжээ хэлбэр нь янз бүрийн олон тооны баримал дурсгалуудтай юм. Эндээс өнгөрсөн түүхээ эрхэмлэн хүндэтгэсэн өнгө аяс тод мэдрэгдэнэ. Алтай хотын төв, дүрслэх урлагийн, угсаатны зүйн үзмэр зэрэг цөм ийм хандлагатай. Эрчис мөрөнд тэднийг ирэхээс өмнө амьдарч байсан уугуул иргэдийн талаар мэдээлэл өгөх зүйлс их ховор юм билээ. Би Оросын Барнаул хотын түүхийн төв музейг үзэж байсан. Тэр музейн хамгийн эхний үзмэрүүдийг нутгийн уугуулуудад зориулан бэлтгэн дэлгэн тавьсан байсан сан. Харин Алтайд бол үгүй юм. Уугуул, суугуулийн аль алиных нь хичээл зүтгэлээс хамаардаг биз ээ. Ийм нэгэн мэдрэмж надад төрж байлаа. Хэрэн голын хөвөөнд цонх нь голруугаа харсан Алтай зочид буудлын гэгээвчээр уулын голын хүчтэй харгиа сонсогдох нь Сэнхэр, Машийн голынхоо хөвөөн дээр дан майхантай амарч хэвтэх мэт бодлыг төрүүлнэ. Харин гудамжинд амьдрал эгээ л том хотын маягаар өрнөж байна. Захаар нь ороход хасаг, монголчууд цагаан идээгээ дэлгэсэн шар, цагаан тос, ааруул, ээзгий, бяслаг, тараг айраг үнэртэнэ. Үрэмчээс ялгаатай нь нүүдэлчдийн нутагт тэдний өв соёл хадгалагдсаар байгааг харуулна. Алтай хотод манай олон улсын хурал өндөрлөж хаалтын хуралдаанаа хийсэн юм. Хурлын гол үзэл санаа нь Торгоны замын дагуу байрших улс орон ард түмнүүдийн түүх соёлын судалгааг эрчимжүүлж, угсаатны онцлог шинжээ хадгалан хөгжүүлэхэд төрийн зүгээс дэмжлэг үзүүлэх, Хятадуудын торго зөөж байсан торгоны замаар өнөөгийн Хятад гүрэн эрчим хүч экспортлон бүс нутгийн орнуудтай хамтын ажиллагаагаа эрчимжүүлэхэд чиглэгдсэн билээ. Тэнд би “Алтайн урианхайчуудын өв соёлын онцлог” сэдвээр илтгэл хэлэлцүүлэв. Алтай хотод ажиллаж амьдарч байгаа хэдэн цөөн алтайн урианхай нар сонсохоор иржээ. Хурлын зохион байгуулалтанд ажиллаж байгаа Буянт гэдэг бүсгүй зар тарааж “...Монгол улсаас нэг урианхай иржээ. Маргадар хуралд үг хэлнэ” гэж хүмүүст сонсогжээ. Уугуул нутгаа сахин цөөнхийн дотор маш цөөнх болон суугаа тэр хэдэн алтайн урианхайд Монголоос хүн ирэх тэр дундаа алтайн урианхай хүн ирэх нь “Өвөг эцэг нь босоод ирсэн мэт” санагдана гэнэ. Бүгд л гэртэй урьж аагтай үстэй цайгаа чанаж өгнө, Хандгайт давхиж хүрээд настай аав ээжтэйгээ уулзуулж “хүүндүүлнэ” гэлцэнэ. Алтайн урианхай гэдэг үг хэлээд бидний нэрийг нэг гаргаад өглөө хэмээн хөөрцөглөнө. Хүүхдүүд нь хятадаар суралцах болж эх хэлээ мартаж

байгаа гэнэ. Хандгайт суманд нь монгол бага сургууль байгаа боловч Монгол хэлнээс бусад хичээл нь хятадаар орж эхэлсэн тул залуус яваандаа бүрэн хятадаар ярьж сэтгэдэг хүмүүс болох ажээ. Энэ бол Хятадад аж төрж байгаа цөөнх угсаатны бүлгүүдэд тохиолдож байгаа асуудал юм. Миний танилцсан Самбуу. Хандгайтын монгол сургуулийн захирлаар ажиллаж байсан, одоо Алтай хотод бизнес эрхлэж байгаа овсгоотой эр. Намайг эхнэртэйгээ цуг яваагаа хэлэхэд тэр надаас "... жинхэнэ бэргэн юу буудлын бэргэн юу" гэж асуусан шүү. Жинхэнэ байлгүй яахав буудлын бэргэн бас ирэхүү гэхэд танай монголоос Ховлоос зарим хүмүүс буудлын бэргэн авч ирдэг юм хэмээн илэн далангүй шулуухан хэлж инээд наргиан болов. Ийм асуудал бас болдог байхнээ. Манай монголчуудаа гэж. Нэг орой бидэнд Хандгайт монгол сумын "урлагчдын" тоглолт үзэх завшаан тохиолдов. Хотын төв талбайд тусгайлан тайз засаж гоёмсог хаяг өлгөжээ. Манайхаар бол жилд нэг удаа Алтай хотод сумдын соёлын өдрүүд зохиодог байна. Монгол өөртөө засах Хандгайт сумын соёлын өдрүүдийн урлагийн тоглолт болж байгаа юм байна. Алтай хотод амьдардаг монголчууд цугларч овоо олон хүн эгнүүлэн зассан сандал дээр суулгааж хүүхэд залуус араар нь эгнэн зогсжээ.

Тоглолт эхлэхийн өмнө Алтай аймгийн иргэдийн хурлын дарга, Хандгайт сумын намын хорооны дарга, засгийн ордны тэргүүлэгч нар, ахмадууд суудлаа эзлэв. Биднийг эх Монголоос ирсэн гэж танилцуулан хүндэтгэлийн суудалд суулган төдөлгүй урт гэгчийн цагаан хадаг намируулан авч ирээд хүзүүнд "тохож" өглөө. Тоглолт эхлэв. Сүрхий хэлэмгий залуу уран цэцэн үгээр урсгана. Дэргэд нь зогсох бүсгүй хятадаар орчуулна. Ихэнхи дуу хуур нь хятадаар явах юм аа. Монгол хувцастай охид хөвгүүд монгол ардын дуу хэмээн зарлаад хятадаар дуулгаах ажээ. Хандгайт суманд багтах хасаг, хятадуудын урлагийн тоглолт бас байна. Харин алтайн урианхайн цуур хөгжим тэнд уг язгуураараа халгалагдсан нь нэн таашаалтай. Алдарт цуурч гэж зарлуулсан тариачин залуу цуурийг үнэхээр сайн үлээж байсан шүү. Өвөрмонголоос морин хуурч урин ирээд залууст заалгаж байгаа юм байна. Савардан биелгээгээ сайн хийцгээнэ. Савардангаа үзэгчид, тоглогчид бүгд нийлээд босон суун хийцгээх юм.

"Савардан, савардан, савардан сайхан бүсгүйчүүд биелэнэ

Эс биелэгсэн бүсгүйг элээ шовуун тоншино" хэмээн цовоо дуугаар зарламагц хөгшин залуугүй бүгд ухасхийн босоод хоёр хөлөө зөрүүлэн тавиад цээжээ хөдөлгөн гараа үелзүүлэн савардангаа эцэж цуцахыг мэдэхгүйгээр эрчимтэй биелэн цэнгэлдэх юм аа. Тоглолтын

дундуур усархаг аадар бороо цутган түр тасалдуулснаас өөр саатал гарсангүй. Харин ч цугларагсад Алтайн савдаг баясаж хураа хайрлав гэгцгээнэ. Алтай хотод сурч амьдардаг залуус орчин үеийн реп маягийн бүжиг бас хийцгээв. "...цовоо цолгин хөвүүд залуус зах зээлийн биелэг гаргаад иржээ" гэж зарлангуут хэдэн хөвгүүд тайзан дээр үсрэн гарч ирээд реп бүжнэ. Ийнхүү цөөн алтайн урианхай нар өв соёлоо хадгалахыг эрмэлзэн орчин цагийн урлагт суралцахыг хичээн аж төрж байна. Тэр орой Алтайд цугларсан монгол угсаатнуудын хувьд угсаа түүх өв соёлоороо бахархах сэтгэл тэмүүллийг нь сэргээсэн, ойр холоос цугларан аж амьдралаа хүүрнэх сайхан боломж ирэх шигээ.



Алтай аймгийн Хандгайт монгол сумын цуурч .2012.08.10

Алтай хотод ажлаа дуусгаад бид Үрэмч рүү эргэлээ. Эрчим мөрний урсгал даган Алтайн нуруунаас бууж говь цөлийн бүсрүүгээ эргэж байна гэсэн үг юм. Эрчисийн эрэг дагуу дан хятад иргэдээс бүрдсэн эрдэнэ шиш, малын тэжээл голлон тариалсан тосгон олон тоотой. 1949 онд Коммунист намын удирдлагаар БНХАУ байгуулагдсаны дараагаар армид алба хааж байсан цэргүүдийг Эрчим мөрний хөвөө дагуу суурьшуулан газар олгож гэр бүлээ авч ирэхийг зөвшөөрсөн нь эдүгээгийн хятад тосгодын эх суурийг тавьж өгчээ. Тосгон суурин нь нэг маягийн ижилдүү зохион байгуулалттай. Сайн засмал замаар холбогдсон, том услалтын сувгуудтай юм. Үрэмч хүрэх замдаа Хятад, Казакстаны хил дээр очиж Хабахийн гэж нэрлэгдсэн эртний хүний урлал хадны сүг зурагтай, Ховог сайр аймгийн Хош толхой монгол балгасанд хүрч Жангарын овоотой танилцав. Энэ Жангарын овоог бидний танил Ховог сайрын торгууд

эдүгээ Өвөрмонголын их сургуульд багшилж байгаа нэрт Жангар судлаач Таяа багшийн санаачлага оролцоотойгоор бүтээн босгожээ. Зүүн гарын хотгорт зоосон хонин сүрэг мэт тоймгүй олон жижигхэн газрын тос олборлох байгууламжуудыг харж “гайхалдав”. Манай Их хурал, Засгийн газар Дорнотын талд газрын тосны үйлдвэр барина гэж лав л хорин жил болсон санагдана. Ерөнхийлөгч асан Очирбат гуайн цагаан дээлэндээ түрхсэн хар тос одоо хатаад удсан байх даа. Харин хятадуудын барьсан газрын тосны үйлдвэр гэж жижигхэн худаг маягийн байгууламжууд жирийлдэн эрээлжлэн “өөрсдөө” ажиллацгааж байна. Хүнд нүсэр дааж давшгүй том юм харагдсангүй. Бид яаж мэдхэв дээ хөөрхий. Суусан цэцнээс явсан тэнэг дээрээ гэж үнэн үг юм аа.

Үрэмч-Ховд-Улаанбаатар. 2012. 11 сар

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

¹ 1762 онд Алтайн урианхайн 7 хошууны Эрчис голын баруун дахь 3 хошууг Баруун гар, зүүн дахь 4 хошууг Зүүн гар хэмээн нэрийджээ. 1907 онд Манж нар Ховдын хязгаарыг Ховдын хязгаар, Алтайн хязгаар хэмээн хоёр хуваахад алтайн урианхайчууд хоёр газар завсардан 1915-1927 оныг хүртэл харъяалал нь тодорхой бус байсаар 1930-аад оноос хил тодорхой болоход Монгол, Хятад хоёр улсад хуваагдан суужээ. Эдүгээ Зүүн гарын чуулганы алтайн урианхайчууд зарим хэсэг нь Шинжианы Алтай аймгийн Хаавай сяны Цагаан Хаабай тосгон, Хандгайт тосгон, Алтай сян, Хөх тохой сян, Тэмэг зэрэг газраар, Баруун гарын чуулганы Алтайн урианхайчууд нэг хэсэг Шинжааны Алтай аймгийн Хаавай сяны Цагаан Хаабай тосгон, Алтай сян, Хөх тохой сян, Буржин сян, Чингэл сянд цөөн тоогоор тархмал амьдарч байна.

² Алтайн урианхайн Баруун гарын Дархан бэйсийн хошуу нь дотроо Ах, Мянгад, Оорцог, Цэрвээ гэсэн дөрвөн сумтай байв. Оорцог суманд баян чинээлэг малчид голдуу харъяалагдаж явжээ.

³ Алтайн урианхайн Баруун гарын Дархан бэйсийн хошууны Их хүрээний Да лам, хошуу ноён. Самбуу тайжийн хүү Чүлтэм да лам (1886-1942) нэг хэсэг хугацаанд хошууныхаа шашин төрийг хослон барьж байгаад 1930 онд албат ардынхаа нэг хэсгийг дагуулан хил даван нүүж Чингэл голд хүрэн нутаглаж 1939 онд хошуу ноёны тушаалаас бууж Цонжид хүрэн амьдарч байсан. Тэрээр Зүүнтний нугалааны үед ардын засгийн бодлогын эсэргүйцэн хил даган нүүсэн их нүүдлийг эхлүүлжээ.

⁴ Хорхон бол алтайн урианхайн дотор байх олон овогуудын нэг. Алтайн урианхайн баруун гарт овогийг элкэн, Зүүн гарт яс хэмээн нэрлэнэ. Аман ярианд “Хорхоны нүдэн хорхойтой” гэлцэнэ.

⁵ Бидний Монголчууд казах гэдэг бол Шинжааны хүн ард хасаг хэмээнэ. Шинжааны казахууд өөрсдөө ч бид хасаг гэж хэлэлцэнэ. Угсаатны уугуул нэр нь хасаг юм. Казах нь Оросын хаант улсын үеийн цэргийн зохион байгуулалтаас үүдэн гарсан нэр болой.

⁶ Шинжааны монголчуудын тайлбарлаж байгаагаар энэ үг “Шинээр эргэж ирсэн хязгаар нутаг” гэсэн агуулгатай ажээ.

⁷ ШУӨЗО-ны Алтай аймаг бол Хасаг өөртөө засах аймаг юм. Хүн амын ихэнхийг хасагууд эзлэнэ. Дараа нь хятад, монгол, уйгур, хуухуй нар орох ажээ. Төв нь Хэрэн голын хөвөөнд байрлах Алтай хот.

⁸ Баян-Өлгий аймгийн Алтай сумын нутагтай хил залгана. Даянгийн боомтоос 100 орчим км газар ажээ.

⁹ Дунд хэмжээний чулуун урлал ээмэг зүүлт зэрэг нь дунджаар арван таван мянган төгрөг байна.

¹⁰ Энэ урианхай нар Алтайн урианхайн Зүүн гарын урианхай хошуунаас салбарлан салжээ. Монгол улсын Баян-Өлгий аймгийн Алтай, Буянт сумдад ах дүү нар нь голлон сууна.